ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Булган сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2025/042/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2025 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207, Цахим хаяг:narmandakhd@audit.gov.mn Аудитор: М.Ухаанбилэг Утас: 7058-4204, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт..... 3-4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....5-9

3. Аудитын илрүүлэлт 10

4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....11

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.24 № 294

танай_____-ны №_____-т

ДОРНОД АЙМГИЙН БУЛГАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.СЭЛЭНГЭ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь 29.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй санхүүгийн тайланг баталгаажуулж ирүүлсэн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. 2024 оны санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгийн тооллогыг хийж баталгаажуулаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, өр төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ.”, 12.2.1-т “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” заалттай нийцээхгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Төсвийн санхүүгийн сахилга батыг мөрдөж, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогыг баримтлан ажиллаагүй байна.

011022161

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргаар үнэлүүлж ажиллаагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	**ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН**	**-**	**291,771.52**
33	**АВЛАГА**	-	291,771.52
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	291,771.52
2	**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН**	**2,444,566.69**	**1,934,187.29**
39	**ҮНДСЭН ХӨРӨНГӨ**	2,444,566.69	1,934,187.29
392	**Биет хөрөнгө**	2,444,566.69	1,934,187.29
39203	Авто-тээврийн хэрэгсэл	24,000,000.00	24,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(24,000,000.00)	(24,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,769,789.00	3,769,789.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,197,222.47)	(2,535,601.47)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,829,000.00	1,829,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,214,499.80)	(1,329,000.16)
39214	Бусад үндсэн хөрөнгө	345,000.00	345,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(87,500.04)	(145,000.08)
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II**	**2,444,566.69**	**2,225,958.81**
4	**НИЙТ ӨР ТӨЛБӨР**	**-**	**291,771.52**
41	**БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР**	-	291,771.52
413	**Өглөг**	-	291,771.52
4136	**Бусад өглөг**	-	291,771.52
41361	Байгууллагад төлөх өглөг	-	291,771.52
5	**ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**	**2,444,566.69**	**1,934,187.29**
51	**Засгийн газрын хувь оролцоо**	2,444,566.69	1,934,187.29
512	**Хуримтлагдсан үр дүн**	2,444,566.69	1,934,187.29
51210	Өмнөх үеийн үр дүн	2,954,945.77	2,444,566.69
51220	Тайлант үеийн үр дүн	(510,379.08)	(510,379.40)
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V**	**2,444,566.69**	**2,225,958.81**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)**	**155,882,800.00**	**167,385,200.00**
11	**ТАТВАРЫН ОРЛОГО**	**-**	**-**
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**155,882,800.00**	**167,385,200.00**
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	41,500,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41,500,000.00	-
1320	**Орон нутгийн төсвөөс санхүүжих**	114,382,800.00	167,385,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	106,689,900.00	167,385,200.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	7,692,900.00	-
2	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	**156,393,179.08**	**167,895,579.40**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**156,393,179.08**	**167,895,579.40**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	118,330,147.72	93,537,344.69
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	62,549,635.64	67,590,734.75
210101	Үндсэн цалин	36,687,156.75	43,678,962.00

210102	Нэмэгдэл	21,503,502.89	21,720,717.00
210104	Урамшуулал	4,358,976.00	2,191,055.75
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	7,031,633.00	7,769,530.54
210201	Тэтгэврийн даатгал	5,019,037.83	5,898,086.22
210202	Тэтгэмжийн даатгал	603,597.39	702,421.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	482,877.48	374,922.90
210204	Ажилгүйдлийн даатгал	84,193.31	155,847.93
210205	Эрүүл мэндийн даатгал	841,926.99	638,251.70
2104	**Хангамж, бараа материалын зардал**	1,998,500.00	8,597,200.00
210401	Бичиг хэрэг	298,500.00	3,600,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,600,000.00	3,696,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	100,000.00	1,300,700.00
2107	**Томилолт, зочны зардал**	1,180,000.00	3,000,000.00
210702	Дотоод албан томилолт	1,180,000.00	3,000,000.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	360,000.00	360,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	360,000.00	360,000.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	45,210,379.08	6,219,879.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,700,000.00	5,709,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	510,379.08	510,379.40
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	38,063,031.36	74,358,234.71
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	36,204,100.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,204,100.00	-
2134	**Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт**	1,858,931.36	74,358,234.71
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,858,931.36	74,358,234.71
3	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)**	**(510,379.08)**	**(510,379.40)**
5	**НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)**	**(510,379.08)**	**(510,379.40)**

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)**	**155,882,800.00**	**167,385,200.00**
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**155,882,800.00**	**167,385,200.00**
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	41,500,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41,500,000.00	-
1320	**Орон нутгийн төсвөөс санхүүжих**	114,382,800.00	167,385,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	106,689,900.00	167,385,200.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	7,692,900.00	-

2	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)**	**155,882,800.00**	**167,385,200.00**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**155,882,800.00**	**167,385,200.00**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**117,819,768.64**	**93,026,965.29**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	62,549,635.64	67,590,734.75
210101	Үндсэн цалин	36,687,156.75	43,678,962.00
210102	Нэмэгдэл	21,503,502.89	21,720,717.00
210104	Урамшуулал	4,358,976.00	2,191,055.75
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	7,031,633.00	7,769,530.54
210201	Тэтгэврийн даатгал	5,019,037.83	5,898,086.22
210202	Тэтгэмжийн даатгал	603,597.39	702,421.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	482,877.48	374,922.90
210204	Ажилгүйдлийн даатгал	84,193.31	155,847.93
210205	Эрүүл мэндийн даатгал	841,926.99	638,251.70
2104	**Хангамж, бараа материалын зардал**	2,198,500.00	8,597,200.00
210401	Бичиг хэрэг	298,500.00	3,600,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,600,000.00	3,696,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00	1,300,700.00
2107	**Томилолт, зочны зардал**	1,180,000.00	3,000,000.00
210702	Дотоод албан томилолт	1,180,000.00	3,000,000.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	360,000.00	360,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	360,000.00	360,000.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	44,500,000.00	5,709,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,500,000.00	5,709,500.00
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**38,063,031.36**	**74,358,234.71**
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	36,204,100.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,204,100.00	-
2134	**Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт**	1,858,931.36	74,358,234.71
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,858,931.36	74,358,234.71
8	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)**	-	-
9	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**		
10	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	**2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл**	0.00	0.00	2,954,945.77	0.00	2,954,945.77
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	**0.00**	**0.00**	**2,954,945.77**	**0.00**	2,954,945.77
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-510,379.08	0.00	-510,379.08
C08	**2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**0.00**	**0.00**	**2,444,566.69**	**0.00**	2,444,566.69
D01	**2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл**	**0.00**	**0.00**	**2,444,566.69**	**0.00**	2,444,566.69
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	**0.00**	**0.00**	**2,444,566.69**	**0.00**	2,444,566.69
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-510,379.40	0.00	-510,379.40
D09	**2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**0.00**	**0.00**	**1,934,187.29**	**0.00**	1,934,187.29

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**		
2	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	167,385,200.00	93,026,965.29
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	167,385,200.00	93,026,965.29
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	167,385,200.00	93,026,965.29
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	133,082,700.00	67,590,734.75
210101	Үндсэн цалин	59,971,600.00	43,678,962.00
210102	Нэмэгдэл	53,190,300.00	21,720,717.00
210104	Урамшуулал	19,920,800.00	2,191,055.75
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	16,635,800.00	7,769,530.54
210201	Тэтгэврийн даатгал	11,312,500.00	5,898,086.22
210202	Тэтгэмжийн даатгал	1,330,800.00	702,421.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,064,700.00	374,922.90
210204	Ажилгүйдлийн даатгал	266,100.00	155,847.93
210205	Эрүүл мэндийн даатгал	2,661,700.00	638,251.70
2104	**Хангамж, бараа материалын зардал**	8,597,200.00	8,597,200.00
210401	Бичиг хэрэг	3,600,000.00	3,600,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,696,500.00	3,696,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,700.00	1,300,700.00
2107	**Томилолт, зочны зардал**	3,000,000.00	3,000,000.00
210702	Дотоод албан томилолт	3,000,000.00	3,000,000.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	360,000.00	360,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	360,000.00	360,000.00

2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	5,709,500.00	5,709,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,709,500.00	5,709,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	167,385,200.00	93,026,965.29
1310	**УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	-	-
1320	**ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	167,385,200.00	93,026,965.29
122005	Орон нутгийн төсвөөс	167,385,200.00	93,026,965.29
4	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	-	-
5	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлтийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 43.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 0.3 сая төгрөгийн 2 алдааг залруулах бичилт хийлгэж, 29.9 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 12.8 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгч ажиллалаа.

Залруулсан алдаа:

- Нийгмийн даатгал болон татварын тайланд 0.2 сая төгрөгийн илүү төлөлттэй байсныг авлагын дансанд тусган, тайланд илэрхийлээгүй нь санхүүгийн тайлангийн аудитын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй.

3.2 Албан шаардлага

Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь тайлант хугацааны жилийн эцэст эд хөрөнгийн тооллого хийх тушаал шийдвэр гаргаагүй, тооллогыг зохион байгуулж ажиллаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн “12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Монгол Улсын Засаг Захиргаа, Нутаг Дэвсгэрийн Нэгж, Түүний Удирдлагын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн сонгуулийн үр дүнд чөлөөлөгдсөн аймгийн ИТХ-ын даргад Монгол Улсын Засаг Захиргаа, Нутаг Дэвсгэрийн Нэгж, Түүний Удирдлагын тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 -д "Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно." гэж заасны дагуу 12.9 сая төгрөгийн тэтгэмжийг бодож олгоогүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн сонгуулийн үр дүнд чөлөөлөгдсөн албан тушаалтанд олгох тэтгэмжийг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллах зөвлөмж өгөх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох

бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”. Харин зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул-аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварыг 290.2 мянган төгрөгөөр илүү тайлагнаж авлагаар тусгаагүй байна.	1	290,2	1	290,2			1	290,2	-	-	-	-
Нийгмийн даатгалын санд ажил олгогчийн шимтгэл илүү төлөлттэй гарсныг авлагаар тусгаагүй байна.	1	1,5	1	1.5			1	1.5				
Дүн	2	291,7	2	291,7			2	291,7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт-ны тоо	Тоо	Дүн
Орон нутгийн сонгуулийн үр дүнд чөлөөлөгдсөн албан тушаалтанд олгох тэтгэмжийг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллах	1	12,870.0	-	-	-	-	1	12,870.0	-	-	-	-
Жилийн эцэст үндсэн хөрөнгийн тооллого хийх тушаал шийдвэр гаргаагүй, уг тооллогыг хийж ажиллаагүй байна.	1	29,943.8			1	29,943.8						
Дүн	**2**	**42,813.0**	-	-	1	**29,943.8**	**1**	**12,870.0**	**-**	**-**	-	-

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 58 ДОА-2025/040/НА-СТА-ТШЗ Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-т заасны дагуу Дорнод аймгийн Булган сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Булган сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2024 оны жилийн эцэст хөрөнгийн тооллого хийхгүй санхүүгийн тайлан гаргаж ажилласан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "12.2.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:", 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй;", 4.2.1.2-т "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй;" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндсэн хөрөнгийн 29,943,789 /хорин есөн сая есөн зуун дөчин гурван мянга долоон зуун наян ес/ төгрөгийн хөрөнгийн биет тооллогыг хийж, биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлж ажиллахыг Дорнод аймгийн Булган сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Сэлэнгэ, нягтлан бодогч Ө.Мөнхцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

АУДИТОР М.УХААНБИЛЭГ

2125040100